

МОНГОЛ ХЭЛНИЙ “НҮҮР” ХЭМЭЭХ ҮГИЙН ГАРАЛ ҮҮСЭЛ, УТГЫН ЗОХИЦОЛ, ХЭРЭГЛЭЭ

Д.Баасанбат*

Энэ үгийг монгол бичигт “нигур” (энэ цагт нүүрийг хүндэтгэсэн утгаар хэрэглэж байна) хэмээн бичих бөгөөд, “ni” язгуурт “niyu” үндэст үг буриадын аялгуунд “и” хэвээр (*n'ir* = *нюур*), халх аялгуунд “й”-тэй болж “нүүр” хэмээн хэлдэг байна.

Үүнийг цуваа цагийн үүднээс “й” авианы хувьсал нь (*biγay-u*-бяруу, *niγur*-нүүр) г.м нэр үг бүтээсэн гэж үздэг¹.

Сүүлийн “-р” дагавар нь монгол хэлний “юм” гэсэн утгыг заасан үйлээс нэр үүсгэх дагавар юм. “Нүүр” хэмээх үг нь эхэн үедээ нуудаг юм, нуудаг зүйл гэсэн утгатай байжээ.

Монгол хэлний “ни” язгуураас нуу-(нигу), нуух, нууц, нуувч, нуугдал, нуулт, нуумал, нууцгай, нуудгай, нуузнах, нуулгах, нуулцах, нуусхийх, нууцалзнах, нууцалцгаах, нууцалчихах, нууцат, нууцгаах нууцгайлах, нууцгайхан, нууцлаг, нууцлагдах, нууцлагдмал, нууцлал, нууцлалт, нууцлах, нууцлуулах, нууцчилах, нуучихах, нүүр(нигур), нүүрдүүлэх, нүүрдэх, нүүрлүүлэх, нүүрлүүрдэх, нүүрлэгдэх, нүүрэлдүүлэх, нүүрлэлдэх, нүүрлэлцэх, нүүрлэх, нүүрлэцгээх, нүүрлэчихэх, нүүрсэг, нүүрчлэл, нүүрчлэх, нүүрэвч, нүүрэлдлэг, нүүрэлдүүлэх, нүүрэлдчихэх, нүүрэлдэх, нүүрэлдэцгээх, нүүрэмгий, нүүрэмгийдүү, ний нуугүй (нууж далдлах юмгүй), ниндар(бурхны өмнүүр татах хөшиг), нинж(нигүүлсэхүй, багачууд дүү нараа хайрлах сэтгэл), нүүрэвч, нүүрц(бие биеэрээ уулзах), нүгэл(нигүл), нүгэлгүй, нүгэлт, нүгэлтэй, нүгүүлс, нигүүлсэнгүй” г.м. төрөл үгийн үүр үүсчээ.

Нүүр бол бие хүний үнэ цэнийг илэрхийлэх, хүнийг сайн сайхан байлгах, тал бүрээр хөгжүүлэх, хүнд таатай, нийгмийн амьдралын нөхцөл бүрдүүлэхэд их нөлөөлөхийн зэрэгцээ, бодит юм, баталгаатай юм, тодорхой юм. Харин царай, зүс бол хийсвэр юм учраас зөвхөн сэтгэлд л байна. Жишээ нь: цай ч үгүй царай ч үгүй, байж байгаа царайгий нь.г.м. Нүүрэндээ багтаах юм бол царай, зүс. Уйгар түрэг хэлэнд “*jus*” гэх ба нүүрийн багийг “*nikar*” гэнэ. Монгол бичгээр “нигурувчи” (нүүрийн халхавч) гэнэ.

“Нүүр” хэмээх үгийн ярианы найруулгын утгын төвшин нь:

- нигур (хүндэтгэл утга),
- нүүр, зүс, царай (ерийн утга),
- хар арьс, үрчгэр улаан (дорд утга) байхаас гадна,

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

¹ Базаррагчаа.М, *Эртний монгол хэлний үгийн бүтэц тогтолцоо*, Уб.,2005,

-миний муу “үрчгэр улаан юм”(охин) гэвэл нялх амьтан гэсэн (өхөөрдөл) утга байна.

Хүний нүүрийн хэлбэр төрх: нармигар, шармигар, навтагар, палбигар, халмигар (хувирамтгай), тэгш, зууван, дугуй, гонзгой, өргөн, хавчиг, хавтгай, модгор мордгор бордигор, мэлгэр, ширлэсэн, манхар, манхан, арсгар, барсгар, нөрөөтэй, сэвхэт, мэнгэт, сорвит, молигор гэх мэт.

Өнгө зүс: цагаан, бор, бордуу, шар, шаравтар, шарлангуй, шардуу хөх, хөхөвтөр, хөхөлбөр, хар, харавтар, хүрэн бор, хүрэндүү, цоохор, улаан зээрд нүүр... г.м.

Монгол хэлний “нүүр” хэмээх үгийг(үглэврийг) хам бүтцийн утгазүйн үүднээс үзвэл, хүн, амьтны толгойн өмнө тал, магнайгаас доод эрүүний зах хүртэлх хэсэг буюу хүний царай, юмны өвөр буюу өнгөн тал, хүмүүсийн хоорондын найр тал, ном, сонин, сэтгүүлийн хуудасны нэг тал, блогийн нүүр, нүүр хуудас, мэдээ, албан бичгийн эхэнд хэвлэсэн буюу дарсан тусгай тэмдэглэл, сар жилийн эх гэх утгалбартай бөгөөд хэлзүйн үүднээс нэр үг, тодорхой тоо, нэрлэхийн тийн ялгал гэх мэтээр шинжлэгдэх болно.

Цуваа бүтцийн хувиар, нүүр үзэх, нүүр дүүрэн, нүүр баатар, нүүр алдах, нүүрээ барах, нүүр бөх, нүүр түлэх г.м-ээр хэлэхүйн гинжилсэн цуваанд орохдоо үндсэн утга санаа нь өөрчлөгдөн, монгол хүний ой ухаанд биеэрээ уулзах, сэтгэл ихэд ханамжтай инээмсэглэх, ичих зовох зүйлгүй бардам, нэр хүндгүй болох, эсвэл огт ичдэггүй, шившиг болгох, гутаах, сэтгэл зовоох гэх зэрэг санаа буух жишээтэй.

Нүүрлэхэн² (нигурулхан) энэ үгийг хятад галигаас Хейнш, Пеллиө, Лигети, Баяр, Рахевильз нар “*ni'urhan*”, Дашцэдэн “*ниурхан*”, Баяр, Дугаржав, Элдэндэй, Ардажав, Иринчин нар “*нигурхан*” гэж сэргээн оруулсан. Дамдинсүрэн “*бялдуучлан өгч*”, Дугаржав “*нүүр харж зусарлаж өгөөд*” гэж ойлгож зөв орчуулж тайлбарласан.

Хэрэглээний явцад янз бүрийн утгатай болох нь тодорхой. Үндсэн утгаас гадна, утга шилжсэн тохиолдолд буюу мөн чанарыг таньж мэдсэний үр дүнд өвөрмөц олон утга үүснэ. Үгийн сан-утгазүйн шинжээр нь “нүүр” хэмээх нэг утгалбар бүхий дан ба нийлц бүтэцтэй нэгжийн хэлбэр, утгын нэгдэл, мөн чанарыг доорхи байдлаар авч үзлээ.

-Нэг үглэвэр, нэг утгалбар (үг): “*нүүр, нүүрдүүлэх, нүүрдэх, нүүрлүүлэх, нүүрлүүрдэх, нүүрлэгдэх, нүүрэлдүүлэх, нүүрлэлдэх, нүүрлэлцэх, нүүрлэх, нүүрлэцгээх, нүүрлэчихэх, нүүрсэг, нүүрчлэл, нүүрчлэх, нүүрэвч, нүүрэлдлэг, нүүрэлдүүлэх, нүүрэлдчихэх, нүүрэлдэх, нүүрэлдэцгээх, нүүрэмгий, нүүрэмгийдүү г.з. хүн ба амьтны толгойн өмнө этгээд, алив юмын өвөр буюу өнгөн тал, нүүгээд буух шл газар, хүмүүсийн хоорондын найр тал, хуудасны нэг тал, албан бичигт тусгай тэмдэг даргах, сар жилийн эх, уулзуулах, гэрчлүүлэх, ая тал харах*” гэх зэргийн утгалбартай байна.

-Хоёр үглэвэр, нэг утгалбар (хоршоо үг): “*нүүр гар, нүүр ам, нэр нүүр, нүүр нүд, нүүр нүүрээ, нүүр тал, нүүр төрх, овор төрх (хүний нүүр царайны гадаад байдал), нүүр зүс (нүүр зүсэд оо түрхэн энгэсэг бялдсангүй), нүүр нид(харшлах болуужин хэмээн болгоомжилж, нүүр нид, ая тал засах), нүүр нүд(нунтаг элс шороогоор нүүр нүд, толгой түрүүгүй булах), нүүр тал (урьд Жавзандамба хутагтад их нүүр талтай яваад...), нүүр царай (цөм үзэгдээгүй нүүр царай үзэгдэн)*” г.м. ерөнхий, дэлгэр, нэмэлт, хийсвэр утгатай байна.

-Хоёр үглэвэр нэг утгалбар (нийлмэл үг): “*гай, зовлон нүүрлэчихэх (гай, зовлон тохиолдох, учирах), нүүр жалмайх (ичиж зовохыг мэдэхгүй байх), нүүр зулчилзах*

² Монголын нууц товчоо. Уб.,1990,351-р тал.

(ичиж зовсон царай гаргах), нүүр улалзах (ихэд ичих), өвчин нүүрлэх (үргэлж өвдөн зовох), нүүрэнд гарах(эхэнд гарах), нүүр баатар (санаа зовох юмгүй, зориг зүрхтэй, бардам), нүүр үзэх (биеэрээ уулзах), нүүрэмгий хүүхэн (ичдэггүй, санаа зовдоггүй), нүүрний өмнө, нүүрэндээ яртай, нүүрээ бодох, нүүрдэн ярилцах, нүүрлэсэн хаалга, хулгай нүүрлэх, хооронд нь нүүрэлдүүлэх, хэрэгтэн нүүрэлдэх” гэх зэрэг тодорхой утгыг илтгэнэ.

-Хоёр ба түүнээс дээш үглэвэр, нэг утгалбар (өвөрмөц хэллэг): “нэр нүүргүй болох (олонд хүндгүй болох, нэр хүндээ алдах), бөх нүүртэй бүдүүн зүрхтэй(зоригтой ичиж зовохгүй), зузаан нүүртэй (ичиж зовохыг мэдэхгүй), нүүр үзүүлэх (элдэг зан ааш гарган найрсаг хандах), нүүр дүүрэн (тарган цатгалан, сэтгэл ихэд ханамжтай), нүүр алдах, нүүрээ барах(нэр хүндгүй болох), нүүр бөх(ичдэггүй), нүүр нүдгүй (хүчтэй, харах боломжгүй, ширүүн дориун), нүүр түлэх(ичээх, шившиг болгох, гутаах, сэтгэл зовоох), нүүр хагарах(ичиж зовохоо болих, биеэ барихаа болих, танилцах, ойртон нөхөрлөх, ил тодорхой болох, зэвүүцэхгүй болох), нүүр шагнах(нүүрээ харуулах, нүүр өгөх, найрсаг, ая талтай хандах), нүүр харах(танилаар тал тохой татах), нүүр халаах, шарах (ичээх), нүүр халах (ичиж зовох), нүүр халуун (уулзахад ичмээр, санаа зовмоор), нүүр тахлах(хүнд байдалд орсон үед тусалж дэмжин нэр төрийг нь муутгалгүй авч гарах, хийсэн болох, оромдох, ор нэр болгох), нүүр өгөхөд шүүр өгөх (өрөвдөхөд өр өөд өшиглөх), нүүр улалзах(ихэд ичих), нүүр улайх(ичих,зовох), нүүр хийх газаргүй болох (ихэд ичиж зовох, түүнээсээ болж хүний өөдөөс эгц харж чадахгүй байх), нүүргүй(хэлэх эрхгүй, нэр хүндгүй, ичихийг мэдэхгүй, ичих нүүргүй амьтан), нүүрлэх(муу тохиол байна, өвчин, хулгай, зовлон, гай нүүрлэх), нүүрнээс гал гарах, ноцох (маш их ичих, зовох), нүүрээ буруулах(чоно шиг, зангаа хувиргах, уулзахаас зайлсхийх), нүүрээ шатаах(өөрийгөө ичээх), нүүрээ ширлэх (ичиж зовохоо байх, хүн чанаргүй загнах), нүүр баастах (нэр муутгах, нэр бузарлах), нүүр бардам(хүлээсэн үүргээ нүүр бардам хариуцсан шиг хариуцах нь бахархалтай), нүүр нүд болох(хүүхэд, энэ муу амьтан л миний нүүр нүд болж явах юм даа), нүүр өгөхөд бөгс өгөх(даврах), нүүр шүүргүй(увайгүй, нүгэлтэй), нүүрэнд гарах(ичих айхгүй), нүүрээ баран нүдээ хөөдүүлэх(хүний өмнөөс явах), нүүрээ буруулах(зугатах бултах), танил хүний нүүр халуун(төвөгшөөх байдал), улаан нүүрээрээ(өөрийн биеэр, өөрөө, биеэрээ байх, уулзах), усан нүүр, нүдтэй(байнга үйлж байдаг)” гэх мэт бүрдүүлж буй үгийн сангийн утга алдарч холдоод, тэс өөр нэгэн нэгдмэл утга илэрхийлнэ. Хоёр нүүртэн бол ил инээж, далд дайсагнагч, нүгэл нь илэрч нүүр нь танигдахын цагт хоёр нүүртэн гэдэг (хочлолт хэлц³)-ийг хэлүүштэй.

-Хэд хэдэн үглэвэр, нэг утгалбар (хэвшмэл хэллэг): “Нүүрэндээ галтай нүдэндээ цогтой, нүүр өгөхөд бөгс өгөх, нүүр үзвэл бялдуучлах нүх үзвэл шургах, нүүрийн хөө угаавал арилна нүглийн хөө үхэвч арилахгүй, нүүрээ барсан хүн нүдээ анивчих нь олон нүгэл хийсэн хүн нүүрээ буруулах нь олон, нэрээ бодвол хичээж яв нүүрээ бодвол угааж яв, нүүргүй олзоос нүүртэй гарз дээр, нүүр улайж нүд бүлтийх, ичих нүүрэндээ элэг наасан, нүүрийг нь угаах гээд нусаа түрхэх, нүүрээ гээвэл нэрээ гээнэ, нүүрээр мэдэхгүйг сэтгэлээр мэдэх, нүүрэмгий хүүхэн түрэмгий бух хоёр ижил, нүүрээ бодсонд орвол нэрээ бодсон нь дээр, нүүрэн дээр нь ерөөж, нүднээс далд хараах, айх нүүрэндээ арьс наасан, ичих нүүрэндээ илэг наасан, нүүр улайж, нүд бүлтийх, төр төмөр нүүртэй төрсөн бие махан нүүртэй, нэрийн хор нүүрний хир, толинд нүүр царай харагддаг шиг архинд ааш аранин тодордог, сар мэт цагаан нүүрийг барайлгагч архи

³ Т.Галсан. Товчит хэлцийг домгоор тайлагч түлхүүр.2004 х-348.

сайхан сэргэлэн тунгалаг нүдийг гилэргэгч архи..." гэх мэт сургаалын, сургамжийн утга илтгэдэг байна. Мөн "Бур бур буцалмал, бузгай халуун усанд, сэргэлэн оюунаа гээсэн, санчиг нь өл буурал, нүүр улаан даадай" (архичин хүн) гэсэн оньсогод ухаанаа ууж бие эрхтнээ хордуулсан архичин төрхийг шоглон дүрсэлсэн хэвшмэл хэлц ч байна.

Монгол хэлний "нүүр" хэмээх үг нь үгийн сан-утгазүйн хэд хэдэн айд харьяалагдаж, үгийн сангийн бусад нэгжтэй янз бүрийн шүтэлцээтэй байна. Ганц болон олон утга илэрхийлснийг, дан ба нийлц бүтэцтэй утгын нэгдэлд авч үзсэн тул давтсангүй. "Нүүр" гэдэг үгийн ойролцоо утга нь: Нүүр, царай, зүс, дүр, дүр төрх, овор дүр, дүрс төлөв, г.м. жишээ нь: "Нүүрийн хөөг угаавал арилна нүглийн хөө үхэвч арилахгүй. Оог царайдаа түрхэхээс уландаа түрхэхгүй. Зүсээ мэдэхгүй толио муулах, зүрхээ мэдэхгүй ханиа муулах. Нэртэй хүний зүстэй хүү билээ би. Хэнчбиш дотроо нэг дүрсхийснээ биеэ барьж, хэнд ч юм гоморхсон бодол хөврүүлэв. Чагдарын ойролцоо боргио хоржигнон, тэрхүү цойлох урсгалын дотор, өчигдрийн учирсан гоолиг нуруут хар нүдэн охины дүр төрх үзэгдэх шиг болов. Олон жил уулзаагүй найзын минь овор төрх хэвээрээ байна шүү..." г.м.

Үгийн утга нарийн учраас үг болгон хамаагүй нэг дор орж, эв нь таарахгүй ч ёс бий. "Нам тайван" гэх бөгөөтөл "нам амгалан" гэхгүйн адил үгийн зохицол нь бусад үгийг захирч үгийн зохицол үүсдэг. Нүүр, царай, зүс гэсэн ойролцоо үгийг "нүүр харагдтал зүлгэх, царай харагдтал зүлгэх, зүс харагдтал зүлгэх, нүүр харах, зүс харах, царай харах" гэж цөөн тохиолдолд ижил утга илэрхийлж болж байхад, ихэвчлэн "нүүр халуун, зүс халуун, царай халуун, нүүр өгөх, зүс өгөх, царай өгөх" гэх мэтэд тохирохгүй, зохисгүй нь их байна.

"Нүүр" хэмээх үгийн эсрэг утга нь "нүүртэй, нүүргүй" гэх үгээр илэрнэ. Жишээ нь: "Нэр нүүр бүхий (танил талтай), нүүртэй хүн (олонд хүндтэй, танил олонтой хүн)"; "Баян хүн таван хаанд нүүртэй гэдэг"⁴.

Нүүргүй (хэлэх эрхгүй, нэр хүндгүй, нүүр байхгүй, тэднийд очих нүүргүй болов, ичихийг мэдэхгүй, ичих нүүргүй амьтан, нэр нүүргүй болов...) г.м.

"Нүүр" хэмээн нэрлэгдсэн газар нутгийн нэр байдаг. Нүүрэнтэй, Нүүрийн бууц, Нүүр г.м. Энэ нь өндөр уулын урд хэсэг буюу энгэр, нүдэнд илхэн, харууц сайтайгаар нь гэж нэрлэсэн байх ба, "нүүр лүү нь өнгий" гэх үг хэллэг байна. Харин, ардын дуу бол ард түмний эх нутаг, энэрэл хайрын бахархал, магтуу, зан заншил, ёс суртахууны амьд цоморлиг билээ. "Нүүр" хэмээх үг ардын дуунд ер ордоггүй нь их сонин. Хаа нэг царай, зүс гэсэн ойролцоо утгаар хэрэглэгдэж байна.

Хүний нүүр бол хүний янз бүрийн шинж, тэдгээрийн харилцааг сэтгэхүйдээ хийсвэрлэн царай, зүс, төрх, дүр, төлөв, байдал, гэх зэрэг үглэврээр төлөөлүүлж бие хүний үнэ цэнийг илэрхийлэх, хүнийг сайн сайхан байлгах, тал бүрээр хөгжүүлэх, хүнд таатай нийгмийн амьдралын нөхцөлийг бүрдүүлэхэд хэлэхүйн хэрэглээнд орж их нөлөөлнө. Энэ нь нүүр баатар, нүүр бардам, нүүрэндээ галтай нүдэндээ цогтой байж энэ сайхан чанараа цэвэр ариунаар, хадгалж хамгаалан нуун нууцалж байх учиртай. Нүүр оролцсон зарим өвөрмөц хэлцийн утга, үүрэг, хэрэглээний онцлогоос дурдъя.

"Нүдэндээ галтай нүүрэндээ цогтой, шилэндээ шилтэй шилбэндээ чөмөгтэй" гэж хийморьтой золбоотой, хүч чадалтай, цог жавхлан, суу заль бадарсан хүнийг ерөөн бэлгэдсэн ерөөл бэлгийн үгэнд оруулж хэлсэн хэлц үг. Энэ нь яриаг оновчтой яруу чимэгтэй болгох үүргээр хэрэглэдэг мэргэн үг бөгөөд яриа бичигт эрт цагт бол

⁴ О.Цэндсүрэн. Халуун салхи.,

“нүдэндээ галтай нүүрэндээ гэрэтэй” гэж хэлдэг байсан боловч энэхүү “гэрэтэй” гэдэг нь “гэрэлтэй” гэсэн утгатай. Энэ “галту, гэрэтү” гэсэн нь эр хүйст үгс болно. Бөртэ охинд холбогдуулж энэ үгийг “МНТ”-ы 66-р зүйлд гэж хэлсэн нь нэгд эм хүйс зааж хэлсэн, “-тай,-тэй” дагавартайгаар эм хүйс ялган заажээ. Нөгөө талаар энэ нь бас давхар сайхны зүйн өөр учир холбогдолтойг бид анх өгүүлэлд тэмдэглэсэн⁵. Зарим аялгуунд, төв халхын аялгуунд мартагдаж хэрэглэгдэхээ бүрмөсөн больж “нүдэндээ галтай нүүрэндээ цогтой” гэж өөрөөр хэлэх болсон. Манай зохиолын баатрын дүрийг дүрслэхэд эл хэлцийг илүүтэй хэрэглэдэг. Энэ нь бие эрүүл, ухаан саруул хүний нүднээс гал мэт эрчим хүч ялгарч, нүүрнээс нь цог мэт илч гэрэл бадарч байдгийг орчин үеийн их мэдрэмтгий биосперийн багаж хэрэгслээр хэмжин баталжээ. Жишээ нь: “Эзэн хичээвэл заяа хичээнэ” гэдэг мэргэн үг бий. “Худы чинь харвал нүдэндээ галтай нүүрэндээ цогтой сэргэлэн хурц залуу мэт харагдаж байна”⁶.

“Алгын чинээхэн улаан нүүр” хэмээх хэлц үүссэн домог нь: Чоно мал, амьтан барьж, их нүгэл үйлдэж байсан тул бурхан багш түүнийг нүглээс нь ангижруулан, буяны мөрд оруулахаар шийдээд, түүнд Лувсанпэрэнлэй гэж сахилын нэр хайрлан, гурван жил нигүүлсэхүйн сургаал айлдаж ном заажээ. Чоно ч их гэгээрч байх шиг байна гэнэ. Бурхан багш чонын их нигүүлсэхүйн номд хэр зэрэг нэвтэрч, буяны зүг сэтгэл нь хэр зэрэг чиглэж байгааг сорихоор шийдэж, ямаа болон хувираад, чоноос зайтайхан өвс идэж байгаа дүр үзүүлэн байж гэнэ. Нэг харсан чинь “шавь” чоно нь түүн рүү сэмхэн гэтэж байснаа гэнэт дүүлэн хүрч ирж дээ. Бурхан багш дорхноо хүн болж хувирсанд чоно эндүүрснээ мэдэж, нүүрийг нь эгцлэн харж чадахгүй гөлөлзөн байсанд Бурхан багш чонын араншинг хэзээ ч хувирч засаршгүйг мэдээд зөнгөөрөө болог гээд тавьсан гэдэг. Түүнээс хойш чоно, хүний нүүрийг эгцлэн харж чадахгүй, “Хүнд алаг бярууны бяд байх биш, даанч алгын чинээ улаан нүүр гэж айхтар юм бий” гэж ярьдаг болсон гэнэ лээ⁷.

“Ичих нүүртээ элэг наасан” хэмээх хэлц нь ичиж зовохоо болих, эрээ цээрээ алдах, муу үйл үйлдээд огт зовохоо болих утгыг илэрхийлнэ. Энэ тухай зохиолч, яруу найрагч Д.Урианхайн “Нүүргүй амьтан” эссээ нийтлэлд: Монгол хүн, хүнд дургүй нь хүрэхээрээ “ичих нүүрэндээ элэг наасан” амьтан гэдэг. Бас заримдаа “нүүргүй” амьтан гэж ад шоо үзэж байгаа нь дуулддаг. Тэр “нүүргүй” гэсэн нь юу гэсэн үг вэ? гэхээр Хүний нүүр цаанаа гэрэл татуулан тусаж, хүнийг нүүртэй болгодог хүн чанарын гэгээ нь арилсныг хэлж буй хэрэг. Ичдэг нүүр бол хүн хүнээ алдаагүйн ил тэмдэг. Хүн өөрөөсөө ичих юм уу, нөхдөөсөө ичих, ард түмнээсээ ичих, эцэст нь эх орноосоо ичих нүүртэй заавал байх ёстой. Эх орон хэдийгээр хэнийг ч алагчилдаггүй, ад шоо үзэж шоовдорлодоггүй ч гэсэн эх орондоо тус хүргээгүй, хэрэгтэй юм бүтээгээгүй, хоосон гуяа ганзагалаж яваа хүн бүхэн эх орноосоо ичиж түлэгдэх “махан” нүүртэй байх ёстой.

“Нохой нүүртэй” гэх хэлц эртний уран зохиолын дурсгал бичгүүдэд хоёр сэтгэлт буюу хатуу журмыг сахиж чаддагүй шалиг завхай зантай эм хүнийг “нохой”-той адилтгаснаас үзэхэд “МНТ”-ны “эм хүн нохой нүүртэй гэгдлээ биз ээ би” гэдэг жирийн нэг тохиолдлын үг биш зүйр цэцэн үгийн утгатай юм уу, ичгүүр сонжуургүй завхай самуун гэсэн утгат хэвшмэл хэллэг уламжлалт дүр гэж болохоор юм⁸.

⁵ Ш.Гаадамба (1976) Нууц товчооны нууцсаас. х-131-142.

⁶ Б.Ринчен. Заан залуудай. х-114.

⁷ Аким.Г. (2000) Тэнгэрийн нохой. .57-р тал.

⁸ Ш.Гаадамба (1976). МНТ-ны нууцсаас, 47-р тал.

“Төр төмөр нүүртэй төрсөн бие махан нүүртэй” хэлц нь: Төр хэмээгч зөв юманд зөөлөн хандаж, буруу зүйлд “төмөр нүүр”-ээ харуулах ёстой бус уу. Төр төмөр нүүртэй төрсөн бие махан нүүртэй, төрийн үйлс түмний эрх ашгийн төлөө үйлст танил тал, найз нөхөд гэх мэтээр ялгаварлан үзэх зүйл огт үгүй, шулуун шударга байх ёстой гэсэн санааг илэрхийлж яриа бичигт дээрх хэлбэрээр тохиолдох ажээ. Энэ нь төрт ёсыг сахиж явбал хүндэт их нэртэй болдог, төв журмыг дагаж явбал түмэн зүйлийг мэдэж болдог гэдэг билээ. “Та бид 2 цөм түмний төлөө хүчин зүтгэж байгаа тул хөдөөний өчүүхэн өвгөн миний бие эрдэмтэн сайдын сурган сануулсан аливаа мэргэн үгийг сонсох нь түмэн зүй буй за”⁹. Г.М.

Энэ утга “ичих нүүртээ элэг наасан”, “нүүр хийх газар олдохгүй болох”, “нүгэл хийсэн хүн нүүрээ буруулах нь олон”, “нүүр улалзах”, “нүүр зулчилзах” гэх зэрэг хэллэгт нүүрээ нуух, халхлах гэсэн санаа байдгаас гадна, хэн ч зааж өгөөгүй байхад нүүрнийхээ өмнө даавуу барьж байгаад түүнийхээ ард “нуугдах” тэгснээ даавууныхаа араас гэнэт нүүрээ гарган ход ход инээд алдах юм уу эсвэл гараараа нүүрээ дарах мэтээр нуугдаж тоглох буюу бага, жижиг хүүхэд ичиж улайхдаа, нүүрээ дарж, халхлан нуудаг ёсон байсаар байна. Бас баруун монголд хацраа “халх” гэдэг нь мөн л халхалдаг юм гэсэн санаа байсан байж болзошгүй юм¹⁰.

Ер нь сайхан бол ямагт далд, ямагт нууц оршиж байдаг. Аливаа юм нууц байхдаа үнэ цэнэтэй, хиргүй тунгалаг байдаг. Бидний бодоход “МНТ” хэмээх дурсгалт бичиг “нууцлан” хадгалж байсан түүхэн ойллого мөн болохыг гэрчилж байна. Харин тэр “нууц” түүхийг уншсан хүн, овог нийгмийн толгойлогч зэрэг холбогдох хүмүүст өвгөд дээдсийн нь түүхийг ярьж өгөхөд түүнийг сонссон хүмүүс, хэн бүхэн үр хүүхдэдээ бага балчраас нь насанд хүртэл нь олж сонссон, ойлгож мэдсэн ээ дамжуулан ярьж, удмын судраа хойч үеийнхэндээ амаар уламжилдаг заншилтай байсан бололтой. Удам угсаа, гарал төрлөө дээш долоон үед нь хүртэл андахгүй мэддэг болоход өөр зорилгын үүднээс “бичиж нууцалсан” түүхээ амаар уламжлуулан дамжуулдаг байжээ¹¹.

Бас нарийн учир нь хүнд төдий л тодорхой бус далд нууц гэж байна. – “Нууцгай чиг ханилсан бидэн хоёр арга ч үгүй амраг мөнөөс мөн шүү дээ. Монгол ардын дуунаас” нууцгай харах (сэм тандан харах), нууцгай нүдэт (сэм тагнагч) - Биднийг битүүхэн эргэдэг нууцгай нүдэт өөр хэн байж таарах вэ¹². “Нүдэн чинээ тулганд нүглийн гал ноцно” хэмээн (тамхи татах)-ыг далд утгаар оньсоголсон нь түүний хор уршгийн ил шууд ухуулга гэлтэй. Хүн судлалын ухаан хүнийг шинжин танихдаа, биеийн гадаад төрхөөс “нүд, нүүрийг” гол болгон үздэг нь ардын үгийн алдаагүй үнэнийг давхар баталж байна.

Ингэхлээр “нүүр” хэмээх үг маань “нүүрийн буянтай, нүүр баатар, нинж сэтгэлтэй байж, алгын чинээхэн улаан нүүр”-ээ ард олныхоо дунд улайлгахгүй, улалзуулахгүй, сэвтүүлэхгүй, сорвитуулахгүй буруулахгүй, унаган төрхөөр нь хайрлан хамгаалж, чандлан нууцалж авч явж чадваас дээрхи сайхны хариулт болно. Хүний дотоод сэтгэлийн бүх хувирал нүүрээр илэрнэ. Нүүрийн хувьсал бол сэтгэл санааны төлөв байдлыг заана. Нүд бол хүний сэтгэлийг дамжуулна. Айсан хүний нүүр цав цагаан, уурласан хүний нүүр ув улаан, дургүйлхсэн бол үрчийсэн хөв хөх, баярласан


⁹ Б.Ринчен. *Үүрийн туяа*. 54-р тал. 1.

¹⁰ Х.Лувсанбалдан, Ц.Шагдарсүрэн, *Монголчуудын үсэг бичиг үг хэллэгийн түүх гарлаас* Уб., 1986, х-68.

¹¹ *Монголын нууц товчоо*. (1990). Уб. 221-тал.

¹² З.Баттулга. *Хөх тэнгэр*. роман

бол малийсан мантгар цагаан царайтай юм шиг харагдах жишээтэй.. Авахыг л сурснаас биш өгөхийг сураагүй, хийхийг чадахгүй байж хэрэглэхийг нь чаддаг хэн боловч “нэртэй хүний зүстэй хөвүүн” биш, өнөө “нүгэл нүдээ олдог”, “нүгэл нүдээрээ гардаг”, “айх нүүрэндээ арьс наасан, ичих нүүрэндээ элэг наасан амьтан” гэгч нь нүгэл хилэнцтэн болох бус уу?



- **Нүүр+Нууц= Ариун чанар**, (нүүр нууц нь хоорондоо сүлэлдэн илтгэх утга бат байваас ариун чанараа хадгална.)
- **Нүүр+ Нүгэл= Ариун бус**, (Нүүр нүгэл нь холилдон байваас ичих нүүрэндээ элэг наасан мэт болно.)
- **Нууц нүгэл** хоёрын харьцаа нь эсрэгцэх санааг илтгэх бөгөөд энэ нь “нүүр”-тэй хэрхэн холбогдож буйгаараа ялгарна.

РЕЗЮМЕ

В данной статье нами была рассмотрена этимология слова “нүүр” и семантическое гнездо от корня “ni”, а также были выявлены множество специфических значения данного корня с точки зрения диахронного и синхронного среза.

НОМЗҮЙ

- Аким.Г. (2000) *Тэнгэрийн нохой*. Улаанбаатар. 57-р тал
- Баасанбат.Д. (2009) *“Хөх судар”-ын хэвшмэл, хэлц хэллэгүүд*. Улаанбаатар 80-р тал
- Баасанбат.Д. (2008) *“Хөх судар”-ын хоршоо үгийн сан*. Улаанбаатар
- БаттулгаЗ. *Хөх тэнгэр*.
- Батбаяр.Д (2007) *Бүтээхүйн зүй тогтол сайхныг бүтээх нууц*. Улаанбаатар. 19-р тал
- Гаадамба.Ш (1976) *Монголын нууц товчооны нууцсаас*. Улаанбаатар. 47, 131-142-р тал
- Галсан.Т. (2004) *Товчит хэлцийг домгоор тайлагч түлхүүр*. Улаанбаатар. 348-р тал
- Дамдинсүрэн.Ц (1947) *Монголын нууц товчоо*. Улаанбаатар. 181-р тал
- Дэмчигжав.М. *Мэдээ хүргэгч Дампил.*,
- Лувсанбалдан.Х, Шагдарсүрэн.Ц (1986) *Монголчуудын үсэг бичиг үг хэллэгийн түүх гарлаас*. Улаанбаатар. 68-р тал
- Монголын нууц товчоо. (1990), Улаанбаатар., 221, 351-р тал
- Ринчен.Б. *Заан залуудай*. Улаанбаатар. 114-р тал
- Ринчен.Б. *Үүрийн туяа*. Улаанбаатар. 541-р тал
- Урианхайн.Д. *Нүүргүй амьтан* эссэ нийтлэл